



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 117

Төрийн ордон, Улаанбаатар хот

ЗАРИМ БАЙГУУЛЛАГЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.3 дахь заалт, 57.10 дахь хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.9, 76.10 дахь хэсэг, 95 дугаар зүйлийн 95.10 дахь хэсэг, Прокурорын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүний албан тушаалын цалингийн хэмжээг 1 дүгээр хавсралтаар, "Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнд төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-ыг 2 дугаар хавсралтаар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, шүүгч бус гишүүний албан тушаалын цалингийн хэмжээг 3 дугаар хавсралтаар, Шүүхийн сахилгын хорооны дарга, шүүгч бус гишүүний албан тушаалын цалингийн хэмжээг 4 дүгээр хавсралтаар, Бүх шатны шүүхийн шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээг 5 дугаар хавсралтаар, Прокурорын байгууллагын прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг 6 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн тогтоосугай.

2. Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, шүүгч бус гишүүн, Шүүхийн сахилгын хорооны дарга, шүүгч бус гишүүний албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг албан тушаалын цалингийн 40 хувиар, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийн хэмжээг "Шүүгчид нэмэгдэл олгох журам батлах тухай" Улсын Их Хурлын 2021 оны 04 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Шүүгчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, түүнийг олгох журам"-д заасан хувиар, докторын зэргийн нэмэгдлийн хэмжээг мөн тогтоолын 2 дахь заалтад заасан хувиар тус тус тогтоосугай.

3. Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан "Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүний албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Монгол Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 66 дугаар тогтоол, "Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүний төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Монгол Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 67 дугаар тогтоол, "Цалин, нэмэгдлийн хэмжээ тогтоох тухай" Монгол Улсын Их Хурлын 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 06 дугаар тогтоол, "Бүх шатны шүүхийн шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Монгол Улсын Их Хурлын 2015 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 101 дүгээр тогтоол, "Прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Монгол Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 65 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ тогтоолыг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР